


Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
даргын 2019 оны 04-р сарын 14-ны өдрийн
118 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлага	НҮГ - 01:2019
--	---------------

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

1. Зорилго

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээний ерөнхий шаардлагыг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Энэ стандарт нь Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын үйлчилгээний чанарт тавих нийтлэг шаардлагыг тогтоож Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлж буй үйлчилгээнд хамаарна.

3. Норматив ишлэл

Энэ стандартад олон улсын болон үндэсний холбогдох стандартуудыг иш татаж хэрэглэсэн бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орвол хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтална. Үүнд:

- MNS 12.1.010.86, Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Цахилгааны аюулгүй байдал;
- MNS 4244:94, Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал, Ерөнхий шаардлага;
- MNS 4996:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны гэрэлтүүлгийн норм, хэмжих аргад тавигдах ерөнхий шаардлага;
- MNS 4990:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага;
- MNS 4968:2000, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. , Ерөнхий шаардлага.

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1 Нийтлэг үйлчилгээ гэдэг нь ажлын байрны тав тухтай, цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэх зорилготойгоор үзүүлж буй мэргэжлийн, мэргэшсэн цэвэрлэгээ, инженер техникийн болон зоогийн үйлчилгээнээс гадна барилга, эд хөрөнгийн ашиглалтыг уртасгах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн төсвийн хэмнэлттэй багц, иж бүрэн үйлчилгээг;

4.2 Үйлчилгээ

Хүний ажиллах тав тухтай, таатай орчинг бүрдүүлэхийн тулд үзүүлж байгаа ажиллагааг;

4.3 Цэвэрлэгээ

Цэвэр цэмцгэр байлгах үйл ажиллагаа буюу төрөл, зориулалтаас нь хамааран ашиглалтын хугацааг уртасгах зорилгоор хийж буй үйлдлийг;

4.4 Арчилгаа

Элэгдэл хорогдол гарахаас хамгаалж нөхөн засварлах, өнгө үзэмжийг нь сайжруулах үйл ажиллагааг;

4.5 Үйлчилгээний ажилтан, үйлчлэгч

Цэвэрлэгээ, үйлчилгээ гүйцэтгэх ажилтныг тус тус ойлгоно.

5. Үйлчилгээний ажилтанд тавигдах шаардлага

5.1 Үйлчилгээний ажилтанд тавигдах ерөнхий шаардлага:

5.1.1 Үйлчилгээний ажилтан тухайн чиглэлээр сургалтад хамрагдсан, мэргэжлийн үнэмлэхтэй байна.

5.1.2 Үйлчилгээний ажилтны хувцаслалт:

- Энгэрийн тэмдэг бүхий ажлын хувцастай байх;
- Хувцас нь цэвэр, индүүдлэгтэй, толбогүй, ханзарч урагдаагүй байх;
- Хэт тод, том хүзүүний зүүлт, бугуйвч, ээмэг, бөгж, зэрэг гоёл чимэглэлийн зүүлт зүүхгүй байх;
- Нүүрний будалт, үсний өнгө, засалт энгийн, нямбай самнаж ардаа шуусан байх ба үсний хавчаар боолт, даруулга зэрэг нь ажлын хувцасны буюу үсний өнгөтэй ижил байх;
- Гарын хумс байгалиас заяасан өнгөнөөс тод содон биш тунгалаг өнгөтэй, будаг нь холцорч ховхроогүй, богино засалттай, хиргүй, цэвэр байх;
- Гутал, туфль хэт өндөр өсгийгүй, өсгий өлмий нь элэгдээгүй, хэлбэрээ алдаагүй, бараан өнгөтэй, өнгөлсөн байх.

5.2 Үйлчилгээний ажилтны хэрэглэх ажлын багаж, хэрэгсэл

5.2.1 Ажлын дүрэмт хувцас;

5.2.2 Малгай, амны хаалт /ариун цэврийн өрөөний үйлчлэгч/;

5.2.3 Гарын саван;

5.2.4 Эдийн саван;

5.2.5 Угаалгын нунтаг;

5.2.6 Резинэн бээлий;

5.2.7 Цэвэрлэгээний даавуу;

5.2.8 Тоосны алчуур /7 төрлийн зориулалттай байна/. Үүнд:

Албан өрөөнд:

- Цонх арчих;
- Хана, паар арчих;
- Ширээ, шүүгээ, сандал арчих;
- Компьютер, принтерийн хэрэгсэл, толь, шилэн эдлэл ба бусад эд зүйл арчих;
- Шал, шалны хүрээ арчих /гадна, дотор, зааланд хэрэглэгдэх ангилал/;
- Хогийн сав арчих;
- Хаалга, гэрлийн унтраалга арчих.

Ариун цэврийн өрөөнд:

- Угаалтуур, цорго, крант арчих;
- Толь, шил арчих;
- Суултуур, суултуурын таг, хаалт арчих;
- Хана, хаалганы бариул арчих;
- Гар хатаагч, бүх төрлийн цаас тогтоогч, усны татуурга арчих;
- Хогийн сав арчих;
- Шал, шалны хүрээ арчих /дотор, гадна, зааланд хэрэглэгдэх ангилал/.

- 5.2.9 Мебель өнгөлөгч;
- 5.2.10 Шил, толь өнгөлөгч бодис;
- 5.2.11 Цайруулагч /белизна/;
- 5.2.12 Ариутгалын бодис;
- 5.2.13 Хивс цэвэрлэгч бодис;
- 5.2.14 Паркет, плита, чулуун шал өнгөлөгч бодис;
- 5.2.15 Ариун цэврийн өрөөний бодис;
- 5.2.16 Том, жижиг хувин;
- 5.2.17 Шалны мод /maf/;
- 5.2.18 Хогийн шүүр, тосгуур;
- 5.2.19 Тоос сорогч;
- 5.2.20 Хивс, чулуун шал угаагч машин;
- 5.2.21 Өндрийн цэвэрлэгээнд хэрэглэгдэх урт иш;
- 5.2.22 Хамгаалалтын бүс /өндрийн үйлчилгээний ажилтанд/;
- 5.2.23 Хогийн тэргэнцэр /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.24 Шат;
- 5.2.25 Цас түрэгч /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.26 Хүрз /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.27 Цас цохигч /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.28 Дэрсэн шүүр /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.29 Тармуур /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.30 Гар хадуур/гар хайч /гадна талбайн үйлчлэгч нарт/;
- 5.2.31 Сэгсрэгчтэй хувин.

5.3 Үйлчилгээний ажилтны харилцаа, ёс зүй

- 5.3.1 Бусдад зөв боловсон, эелдэг хандана.
- 5.3.2 Бусадтай хүндэтгэлтэй, найрсаг байдлаар харилцана.
- 5.3.3 Үйлчилгээний ажилтан нь ажлын идэвх санаачилгатай байна.
- 5.3.4 Харилцагчаасаа 70-80 см-ийн зайнаас харилцана.

6. Цэвэрлэгээ, үйлчилгээнд тавих шаардлага

6.1 Өдөр тутмын цэвэрлэгээнд тавигдах шаардлагыг А хавсралт, хуваарьт цэвэрлэгээ болон их цэвэрлэгээнд тавигдах шаардлага, технологийн дэс дарааллыг Б хавсралтад тус тус харуулав.

А. ХАВСРАЛТ

/ норматив /

А.1 Өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ

А.1.1 Албан өрөө, хурал, ёслол хүндэтгэлийн танхим, нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ: /2м-ээс доош байрлалтай тавилга, эд хогшил, талбайн цэвэрлэгээг хийнэ./

- өрөөний агаар сэлгэх;
- хог, хаягдлыг гадагшлуулах;
- тавилга, эд хогшлын тоосыг хуурай болон чийгтэй алчуураар арчих, өнгөлөх, толбогүй байлгах;
- ширээ, сандал цэвэр, тоосгүй, толбогүй эмх цэгцтэй байлгах;
- хурлын заалны техник, аппаратур, микрофоныг цэвэрлэх, толбогүй байлгах;
- шилэн гадаргуутай эд хогшлыг цэвэрлэх, толбогүй байлгах;
- цонх, хана, хаалга, хивс, хивсэнцэрийг тоос, шороогүй, тортоггүй цэвэр байлгах;
- цэцэг, чимэглэлийн эдлэлийг арчлах /гоёл чимэглэл, сувенир/, өнгө үзэмжийг нь алдагдуулахгүй байлгах;
- чийгтэй цэвэрлэгээ хийх;
- өрөөний ерөнхий байдал цэвэр цэмцгэр байх.

А.1.2 Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ:

- агаар сэлгэх;
- хог, хаягдлыг гадагшлуулах;
- суултуур, угаалтуурыг цэвэр, толбогүй, үнэргүй байлгах;
- шилэн гадаргуутай эд хогшлыг цэвэрлэж, толбогүй байлгах;
- гар хатаагч, цахилгаан хэрэгслийг тоосгүй, толбогүй байлгах;
- цонх, хана, хаалга, шалыг тоос, шороогүй цэвэр байлгах;
- цэцгийг арчлах;
- чийгтэй цэвэрлэгээ хийх;
- ариутгал хийж нянгүйжүүлэх.

А.1.3 Гадна талбайн цэвэрлэгээ: /орчны 50 метрт хийнэ./

- хогийг цэвэрлэх;
- ногоон байгууламжийг арчлах, өнгө үзэмжийг сэргээх;
- баримлыг тоос шороо, хөө тортоггүй цэвэр байлгах;
- хаягжилт, гэрэлтүүлгийн шон, сандлын гадаргууг цэвэр байлгах;
- тухайн орчинд хамрагдах нийтийн эзэмшлийн зам талбай, байгууллагын гадна шат, явган хүний замын орчинг хоггүй, цас мөсийг тухай бүр арилгаж цэвэрхэн байлгах.

А.2 Хуваарьт цэвэрлэгээ үйлчилгээ /2 метрээс дээш/

А.2.1 Албан өрөө, хурал, ёслол хүндэтгэлийн танхимын 2 метрээс дээш байрлалтай тавилга, эд хогшил, талбайн цэвэрлэгээний хуваарь:

Д/д	Төрөл	Давтамж
1	Таазны тоос буулгах, тортоггүй байлгах	Хагас жилд 1 удаа

2	Гэрлийн бүрхүүл цэвэрлэх, өнгөлөх	Жилд 2 удаа
3	Цонхыг жил бүрийн 4 болон 9 дүгээр сард угааж цэвэрлэх	4 болон 9 дүгээр сард
4	Хананы дээд хэсгийн тоосыг буулгах	Жилд 2 удаа
5	Хананд байрлах чимэглэл, уран зураг, лого, цаг зэрэг эд зүйлсийг арчилж, өнгөлөх/	Сард 1 удаа
6	Хөшиг цэвэрлэх	Жилд 1 удаа
7	Тавилга, эд хогшлын дээд, ар талын тоосыг арчих	Улиралд 1 удаа
8	Зөөлөн буйдангийн цэвэрлэгээ, толбо арилгах	Улиралд 1 удаа
9	Туг, сүлд, баримлын тоосыг буулгах	Сард 1 удаа
10	Хивс, хивсэнцэрийн гүн цэвэрлэгээ хийх	Жилд 2 удаа
11	Булан тохой, гар хүрэхэд хүндрэлтэй талбайг цэвэрлэх	Улиралд 1 удаа
12	Агаар сэлгэгчийн тоосыг буулгах	Улиралд 1 удаа
13	Ариутгал хийх	Сард 1 удаа

А.2.2 Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээний хуваарь:

Д/д	Төрөл	Давтамж
1	Таазны тоос буулгах, хөө тортоггүй байлгах	Жилд 2 удаа
2	Гэрлийн бүрхүүл цэвэрлэх, өнгөлөх	Хагас жилд 1 удаа
3	Хананы дээд хэсгийн тоосыг буулгах	Хагас жилд 1 удаа
4	Хананд байрлах самбар, уран зураг, лого, цаг зэрэг эд зүйлсийг арчилж, өнгөлөх	Сард 1 удаа
5	Туг, сүлд, баримлын тоосыг буулгах	Сард 1 удаа
6	Хөшиг угаах	Жилд 1 удаа
7	Зөөлөн буйдангийн цэвэрлэгээ, толбо арилгах	Улиралд 1 удаа
8	Хяналтын камер, галын дохиоллын хэрэгсэл, агаар сэлгэгчийн тоосыг буулгах	Хагас жилд 1 удаа
9	Ариутгал хийх	Сард 1 удаа

А.2.3 Гадна талбайн цэвэрлэгээ /улирлын онцлогоос хамаарна/:

Д/д	Төрөл	Давтамж
1	Төв хаалганы зорчих хэсгийн чулуун шалыг угаах	Жилд 2 удаа
2	Ногоон байгууламжийг арчлах, өнгө үзэмжийг сэргээх	Дулааны улиралд
3	Цас, мөсийг арилгах, халтиргаагүй байлгах	Хүйтний улиралд
4	Хашаа, хашлагын өнгийг сэргээх	Жилд 2 удаа
5	Дээврийн цас мөсийг арилгах	Жилд 1-2 удаа

6	Барилгын гадна хийцийн эвдрэлийг сэргээн засварлах /шат, довжоо, шатны бариул/	Тухай бүр
---	--	-----------

А.2.4 Хог гадагшлуулах:

Д/д	Төрөл	Давтамж
1	Ахуйн	Тухай бүр
2	Дахин боловсруулагдах	Тухай бүр
3	Хоол, хоол бэлтгэлийн	Тухай бүр
4	Барилгын засварын	Тухай бүр

А.2.5 Ажлын хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ариутгал, арчилгаа:

д/д	Төрөл	Давтамж
1	Хувин /цэвэр усаар зайлж, арчих/	Тухай бүр
2	Алчуур /ариутгах бодистой усанд угааж хатаах/	Тухай бүр
3	Хогийн шүүр, тосгуур /бохирдлыг цэвэрлэх/	Тухай бүр
4	Тоног төхөөрөмж /гадаргууг арчих/	Тухай бүр

А.2.6 Архив, сан хөмрөгийн өрөө

Д/д	Төрөл	Давтамж
1	Архивын бичиг баримт хадгалах журмыг мөрдөж цэвэрлэгээ, үйлчилгээ үзүүлэх	7 хоногт 2 удаа чийгтэй цэвэрлэгээ

А.3 Цэцэг, ногоон байгууламжийн арчилгаа

Д/д	Төрөл	Давтамж
1	Цэцгийн төрөл, тоог нэмэгдүүлэх	Жилд 1 удаа
2	Гадна талбайг зүлэгжүүлэх, мод тарих	Жилд 2 удаа
3	Ногоон байгууламжийг бий болгох	Жилд 1 удаа
4	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа хийх	Тухайн улиралд
5	Цэцэг арчлах, ургуулах зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	Жилд 1 удаа

Б. ХАВСРАЛТ

/ норматив /

ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГААНЫ ДЭС ДАРААЛАЛ**Б.1. Албан тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ**

Үйлчлэгч өрөөнд ороод суугчийн эд зүйл нь бүрэн бүтэн байгаа эсэх, ширээн дээр байгаа бичиг баримт бусад зүйлсийг нарийвчлан анхааралтай ажиглаж, бүгд хэвийн байвал цэвэрлэгээг эхлэнэ. Хэрэв ямар нэгэн өөрчлөлт анзаарагдсан бол тэр дариуд холбогдох өөрийн удирдах албан тушаалтанд мэдэгдэж ажлаа цааш үргэлжлүүлэн хийх эсэх талаар заавар зөвлөгөө авна. Салхивчийг онгойлгож агаар сэлгэлтийг хийнэ.

Б.2 Цонх, цонхны тавцан

Б.2.1 Өвлийн улиралд зөвхөн дотор талын хэсгийн шилийг зориулалтын шил өнгөлөгч бодисыг шүршиж буюу цэвэр бүлээн усаар арчина. Цонхны гадна тал, шилэн ханыг -10 хүртэлх температурт хөлддөггүй зориулалтын бодисоор цэвэрлэж болно.

Б.2.2 Хавар, зуны улиралд /III-IX сард/:

- Дулаалгыг авч гадна тавцангийн шороо, тоосыг унагана.
- Хүрээг угаалгын бодистой бүлээн усаар угааж арчина.
- Өндөр, хэмжээ том цонхыг арчихдаа урт иштэй зориулалтын багажийг ашиглан цэвэрлэнэ.

Б.2.3 Шилийг арчихдаа алчуураа дөрвөлжин эвхэн босоо эсвэл хөндлөн хэлбэрээр арчина.

Б.2.4 Бүрэн бүтэн байдлыг шалгаж эвдрэлийг засуулна:

- Цонхны нугас, бариулын бүрэн бүтэн байдлыг шалгана.
- Гадна, дотно тал, хажуу хананы тоос, шороог хуурай алчуураар арчина.
- Дулаалах, өвлийн бэлтгэл ажилд орно.
- Дулаалга хийхдээ дулаан алдагдаж болох хэсгийг чигжиж өгнө.
- Хөшиг тогтоогчийн тоосыг чийгтэй алчуураар арчина. /улиралд 1 удаа/
- Тавцанг зориулалтын бодисоор угааж чийгтэй алчуураар арчина.

1-р анхааруулга: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөнө.

2-р анхааруулга: Хамгаалалтын бүс хэрэглэнэ.

Санамж : Цонхны шилийг алчуураар дугуй хэлбэрээр арчиж болохгүй. Аливаа эд зүйлс, тавилга, хана, хаалга зэргийг тухайн материалын ширхгийн дагуу арчиж цэвэрлэх хэрэгтэй.

Б.3 Хөшиг

Б.3.1 Материалаас нь шалтгаалан цэвэрлэнэ:

- Даавуун материалтай бол жилд 1 удаа угаалганд өгөх;
- Жалюзан материалтай бол улиралд 1 удаа тоосыг буулгах

Санамж: Өдөр тутам засаж, тэгшилнэ.

Б.4 Халаах хэрэгсэл /радиатор/

Б.4.1 Халаах хэрэгслийн арын хана, цонхны тавцангийн доод хэсэг, шал, шалны хүрээг хамтад нь угааж цэвэрлэнэ.

Б.4.2 Нүүрэн талыг чийгтэй алчуураар өдөр тутам арчина.

1-р анхааруулга: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөнө.

2-р анхааруулга: Тохируулгад өөрчлөлт оруулахгүй, гэмтэл учруулахгүй ажиллана.

Б.5 Хана

Хана нь тосон будаг, эмульс, обой, шохой зэрэг олон янзын гадаргуутай байдаг тул тухайн гадаргууд тохирсон цэвэрлэгээ хийх шаардлагатай. Үүнд:

- Тосон будагтай бол зориулалтын угаалгын бодисыг ашиглан угааж, арчина.
- Угаадаг эмульстэй бол тоосыг нь унагааж чийгтэй алчуураар арчина.
- Обой бол тоосыг нь гөвүүрээр буулгана
- Модон болон явган ханыг зориулалтын угаалгын бодисыг ашиглан угааж хатсаны дараа мебель өнгөлөгчөөр өнгөлж арчина.

Б.6 Хивс, хивсэнцэр

Б.6.1 Хивс, хивсэнцэрийг цэвэрлэхдээ:

- Хивсний тоосыг соруулахдаа эхлээд ар талыг, дараа нь өвөр талыг соруулна.
- Хивсний өвөр талыг соруулахдаа эхлээд хивсний ширхэгийг сөргүүлж, дараа нь буцааж дарж соруулна.
- Шалны тоосонцрыг тоос соруулагчаар соруулна.
- Өнгөн цэвэрлэгээг хийхдээ зориулалтын шингэнтэй хөөсийг гадаргууд түрхэхдээ толбо, бохирдлоос шалтгаалан хугацааг тохируулж, зөөлөн үстэй сойзоор сойздож, чийгтэй алчуураар арчина. /7 хоногт 1 удаа цэвэрлэнэ/
- Гүн цэвэрлэгээг хийхдээ хивс цэвэрлэгч машинаар зориулалтын бодис ашиглан угаана. Бодисын үлдэгдлийг сайтар арчина.
- Хурдан хатаах, өнгийг сэргээх арга хэмжээг авна.

Санамж:

- *Гадаргуугийн материалын бүтцээс хамаарч толбо арилгагчийг сонгоно.*
- *Шаланд сэв суулгах бодис хэрэглэхгүй байна*
- *Өнгийг нь гандуулах хүчтэй бодис хэрэглэхгүй байна.*
- *Суурь цавуулагт өөрчлөлт оруулахгүй цэвэрлэнэ.*
- *Нягтарших, хэв алдахаас болгоомжилно.*

Б.7 Телефон утас, факсын аппарат болон цахилгаан хэрэгсэл

Б.7.1 Телефон утас, факсын аппаратыг чагнаж ажиллагаатай эсэхийг шалгана. Гэмтэлтэй тохиолдолд ахлагчид мэдэгдэж засуулах арга хэмжээ авна.

Б.7.2 Телефон утас, факсын аппарат, нарийн холбоос утсыг савантай алчуураар угааж цэвэрлэн чийгтэй алчуураар саванг арилгаад хуурай алчуураар хаттал нь арчиж өнгөлнө.

- Албан тасалгааны цахилгаан хэрэгсэлд телевизор, ус буцалгагч, халаагуур, агаар сэлгэгч, уртасгагч зэрэг багтана.

- Цахилгаан хэрэглэлийг тухайн эзэмшигчийн зөвшөөрөлтэйгөөр зориулалтын бодис, материал ашиглан цэвэрлэнэ.
- Телевизор, принтер, скайнер, агаар сэлгэгч, халаагуурын гадаргуу, дэлгэцийг чийгтэй ширхэггүй зөөлөн алчуураар арчиж, зориулалтын өнгөлөгчөөр өнгөлнө.

Б.7.3 Ус буцалгагчийн дотор талыг тусгай бодисоор угааж, цэвэр усаар 2-3 удаа зайлах ба гадна талыг нь чийгтэй алчуураар арчиж цэвэрлэнэ.

Санамж: Цэвэрлэгээг эхлэхийн өмнө цахилгааны эх үүсвэрийг салгасан эсэхийг шалгасан байна. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллана.

Б.8 Компьютер түүний иж бүрдэл, телевизор, принтер дагалдах хэрэгсэл

Б.8.1 Компьютер түүний иж бүрдэл, принтер, хувилагчийг алчуураар арчиж, дэлгэцийг шил толь өнгөлөгч шүршин хаттал нь арчиж өнгөлнө.

Б.9 Ширээ, сандал

Б.9.1 Албан өрөөний ширээ, сандалыг хийц, материалын онцлогийг нь харгалзан түүнд тохирох цэвэрлэгээний материалыг сонгож цэвэрлэгээг хийнэ. Мебель ширээг чийгтэй алчуураар сайтар арчин цэвэрлэсний дараа өнгөлөгчийг шүршиж, хуурай алчуураар сайтар арчиж өнгөлнө.

Б.9.2 Сандлын тавцан, бариул, хөл, аравчийг загвараас шалтгаалан завсар хоорондох тоосыг сойзоор сойздож угааж, чийгтэй алчуураар арчина. Ширээ, сандлыг эмх цэгцтэй байрлуулна.

Санамж: Ширээн дээрх бичиг баримтыг хуучин байсан байранд нь зөв байрлуулна.

Б.10 Буйдан, сандал

Б.10.1 Зөөлөн буйдангийн тоосыг соруулж, чийгтэй алчуураар арчих, шинэ толбо үүссэн бол толбыг тусгай зориулалтын бодисоор арилган арчиж, цэгцтэй байрлуулна.

Б.11 Сейф

Сейфний гадна талыг савандаж угаагаад, чийгтэй цэвэр алчуураар арчин хуурай алчуураар өнгөлнө. Төмөр сейфний гадаргууг элдэв бодисгүй хуурай алчуураар арчина.

Б.12 Шкаф, номын тавиур

Б.12.1 Шкаф, номын тавиурын гадна, дотор талыг чийгтэй алчуураар арчиж, мебель өнгөлөгчөөр өнгөлж, шилэн нүүрийг шил толь өнгөлөгч шүршиж хуурай алчуураар өнгөлнө.

Б.13 Толь, өлгүүр бусад эд зүйлс чимэглэл

Б.13.1 Өрөөний чимэглэлд толь, шилэн гадаргуутай тавилга, ханын зураг, бэлэг дурсгалын эд зүйлс, цэцгийн тавиур, цэцэг зэрэг орно.

- Тольны хүрээг чийгтэй алчуураар арчиж, шил толь өнгөлөгч шүршиж хуурай алчуураар өнгөлнө.
- Өлгүүрийг чийгтэй алчуураар арчина.

- Ханын зураг болон бусад эд зүйлийг хуурай болон чийгтэй алчуураар арчиж өнгөлнө.

Б.14 Туг, баримал, дурсгалын зүйл, хиймэл цэцэг

Б.14.1 Туг, баримал, дурсгалын зүйл, хиймэл цэцгийн тоосыг тоос гөвөгчөөр буулгана.

Санамж: Өнгө үзэмж, хэлбэр дүрсийг нь алдагдуулахгүй, эвдэж гэмтээхгүй арчилна.

Б.15 Шалны цэвэрлэгээ

Б.15.1 Шал нь модон, паркетан, хулдаасан, чулуун, гантиган зэрэг олон янз байдаг. Шал, шалны хүрээг цэвэрлэхдээ:

- Паркетан болон модон материалтай бол тусгай зориулалтын бодистой нойтон алчуураар хэт услахгүйгээр, хаттал нь арчина. Сард 1 удаа цэвэрлэгээний зориулалтын бодисоор зураас, гүн хирийг сойзоор үрж цэвэрлэнэ.
- Чулуун бол зориулалтын бодистой нойтон алчуураар угааж, хаттал нь арчина. Хуваарьт цэвэрлэгээний үед зориулалтын машин ашиглаж угаана.
- Хулдаасан материалтай бол угаалгын бодистой халуун бүлээн усаар угааж, хаттал нь арчина.
- Шалны хүрээг өдөр тутам чийгтэй алчуураар арчих ба хуваарьт цэвэрлэгээний үед сойздож угаана.
- Булан тохой, гар хүрэхэд хүндрэлтэй талбайг тавилгын байршлыг нь хөдөлгөж цэвэрлэнэ.

Санамж:

- *Шалны цэвэрлэгээ хийж байх үедээ халтирахаас болгоомжлуулсан анхааруулгын тэмдэглэгээг заавал байршуулсан байна.*
- *Шал угааж байх үед халтиргаа үүсэхээс болгоомжилж, саван болон нунтаг бодисыг хөлд өртөхөөр ил байлгаж болохгүй.*

Б.16. Хогийг гадагшлуулах

Б.16.1 Хогийг авахдаа зориулалтын уутны амыг хумхиж авна. /өдөрт 2 удаа/

Б.16.2 Хогийн савны дотор, гадна талыг угааж ариутгана.

Б.16.3 Хогийн саванд уутыг нь углаж тавина.

Санамж: Эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн заавал зориулалтын уут хэрэглэнэ.

Б.17 Хаалга, хаалганы бариул

Б.17.1 Хаалга нь тосон будагтай, лакадсан, хуулган гадаргуутай, шилэн зэрэг олон янз байдаг тул хийц бүтцээс нь шалтгаалан цэвэрлэгээний аргачлал нь өөр өөр байна. Хаалгыг материалаас нь шалтгаалан:

- Тосон будагтай бол угаалгын бодистой халуун бүлээн усаар угааж, хана, хаалганы нугасны тоос шороог чийгтэй алчуураар арчина.
- Лакадсан гадаргуутай бол угаалгын бодистой халуун бүлээн усаар угааж, хана, хаалганы нугасны тоос шороог чийгтэй алчуураар арчиж, хаалгыг мебель өнгөлөгчөөр өнгөлнө.

- Хуулган гадаргуу болон хаалганы нугасны тоос шороог чийгтэй алчуураар арчина.
- Шилэн бол халуун бүлээн усаар угааж, шил өнгөлөгчөөр өнгөлнө.
- Хаалганы бариулыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлж ариутгалын бодистой чийгтэй алчуураар байнга арчина.
- Салхивчийг хааж хөшиг, тюлийг тэгшилнэ.
- Унтраалгын гадаргууг угаалгын бодистой алчуураар арчиж цэвэрлэн, хуурай алчуураар хаттал нь арчаад гэрлээ унтраана.
- Хаалганы бариулыг цэвэр чийгтэй алчуураар арчиж цэвэрлэгээг дуусгана.

Б.18 Цэцэг, ногоон байгууламжийг арчлах технологи дэс дараалал

Б.18.1 Цэцгийг агротехникийн дагуу арчлах, ургуулах, үржүүлэхдээ:

- Хөрсийг сийрэгжүүлнэ. /7 хоногт 1 удаа/
- Цэцэг тус бүрийн онцлогийг харгалзаж, зориулалтын бордоогоор хөрсийг бордоно. /улиралд 1 удаа/
- Хөгширсөн, буруу ургалттай цэцгэнд цэвэрлэгээний огтлол хийнэ. /байнга/
- Хөрсийг шинэчлэхдээ цэцгэнд угаалга хийж шилжүүлэн суулгана. /жилд 1 удаа/
- Цэцэг өвчилсөн тохиолдолд цэцгийг өвчлүүлж байгаа хортон шавьжийг зориулалтын бодисоор шүршиж устгана. /тухай бүр/
- Шинээр тарьсан цэцэг ургалттай байхад анхаарна. /байнга/

Б.18.2 Ногоон байгууламжийг бий болгохдоо:

- Талбайг цэцэг тус бүрт хуваарилж зүлэгжүүлнэ.
- Өнгө үзэмж, дизайнтай нэг наст цэцгийн мандлыг бий болгоно. /5-6-р саруудад/
- Модны суулгацыг шинээр суулгаж арчилж тордоно. /жилд 1 удаа/
- Ургаа модыг хэлбэржүүлэх тайралтыг хийж, бордоогоор хөрсийг бордоно. /жилд 1 удаа/

Б.19. Барилгын засварын дараах цэвэрлэгээ

Б.19.1 Бохирдлыг цэвэрлэхийн тулд тусгай зориулалтын багаж, бодис ашиглаж хийнэ. Барилгын засварын дараах хогийг гадагшлуулахдаа:

- 10 хүртэлх кг жинтэй том оврын хогийг зөөвөрлөж гаргана.
- 10 хүртэлх кг жинтэйгээр багцалж уут, шуудайнд хийж гадагшлуулна.
- Тусгай ангиллын хогонд оруулж ангилна.

Бохирдлыг цэвэрлэх, будагны толбо арилгахдаа:

- Хатуу чулуу, хиймэл чулуун, шилэн, тэгш гадаргуу дээрхийг хусуур, цаасны хутгаар хусаж арилгана.
- Зөөлөн болон, тэгш бус гадаргуун дээрхийг тусгай бодис ашиглаж арчиж арилгана. /бодис нь тусгай зориулалтын бодис, будаг шингэлэгч байж болно/

Эмульсны толбыг арилгахдаа:

- Хатуу чулуу, хиймэл чулуун, шилэн, тэгш гадаргуу дээрхийг усаар норгож хусаж авна.
- Зөөлөн гадаргуу дээрхийг хусуур, цаасны хутгаар хусаж арилгана.

- Цаасан гадаргуу бол хуурай алчуураар арчиж авна.

Селекон, скотчны цавууг арилгахдаа:

- Хатуу чулуу, хиймэл чулуун, шилэн, тэгш гадаргуу дээрхийг хусуур, цаасны хутгаар хусаж арилгана.
- Зөөлөн болон, тэгш бус гадаргуун дээрхийг ургамлын тосоор арчиж хуулж авна. Дараа нь гадаргууг тосны толбо арилгагч бодистой усаар угаана.
- Цементийн толбыг хусаж арилгана.

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.5-д заасны дагуу энэхүү стандартыг бүрэн эсхүл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү Нийтлэг үйлчилгээний газарт хадгалагдана.